



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/18

Эрдэнэт

Г Гүйлтийн цанын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйлтийн цанын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн Төв аймгийн Бор нуур суманд 2022 оны 02 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд зохиогдох тул багийн 15 тамирчин, 3 дасгалжуулагч, 2 жолоочийн байр, хоол, унааны зардлын төсөвт 2,257,440 (хоёр сая хоёр зуун тавин долоон мянга дөрвөн зуун дөч) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Тэмцээнд зарцуулагдах 2,257,440 (хоёр сая хоёр зуун тавин долоон мянга дөрвөн зуун дөч) төгрөгийг зохих журмын дагуу спорт арга хэмжээний зардалаас гаргахыг нягтлан бодогч (Б.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

112
Биеийн тамир, Спортын газрын даргын
2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн
018.....дугаар тушаалын хавсралт

ГҮЙЛТИЙН ЦАНЫН ӨСВӨРИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНД ОРХОН АЙМГААС ОРОЛЦОХ БАГ,
ТАМИРЧДЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Тус тэмцээний зардалд Эрдэнэт-Төв аймаг Борнуур сум-2 талдаа 600км,
дотор явалт-200 км

Бензин А-92 - /1л-2,390төгрөг,100км-д х 20л/

Газ - /1л-1,890 төгрөг, 100км-д х 17л/

1.Шатахууны зардал:

160л х 2,390 төгрөг= 382,400 төгрөг

Газны зардалд - 136л х 1,890 төгрөг = 257,040 төгрөг

Тосол - 3л х 5,000төгрөг= 15,000 төгрөг

Масло -1 л х 3,000 төгрөг= 3,000 төгрөг

2. Хоол:

20 хүн х 5 өдөр х 8,000 төгрөг = 800,000 төгрөг

3. Байр:

20 хүн х 5 өдөр х 8,000 төгрөг= 800,000 төгрөг

Төсвийн нийт дүн: 2,257,440 төгрөг

----oOo----